


# ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

## 02.17 - 02.21



## ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

**АНУ:** Амралтын өдөр таарсан энэ долоо хоногт COVID-19-ийн тархалт дэлхийн эдийн засагт үзүүлэх нөлөөтэй холбоотой АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд уналттай байлаа.

S&P 500 индекс болон технологийн компаниудыг илүү агуулдаг Nasdaq индексүүд Лхагва гарагт хүртэл түүхэн дээд ханшид хүрсэн ч Пүрэв гарагаас эхлэн буурсан ба долоо хоногийн сүүл үе гэхэд зах зээлийн үнэлгээ багатай индексүүд хамгийн сайн үзүүлэлттэй байжээ.

S&P индексийн сагсанд багтах технологийн салбарын компаниудын ханш Азид нийлүүлэлтийн шугамуудад доголдол гарна гэх айдсаас үүдэн хамгийн их бууралттай байлаа. ViacomCBS компанийн ашиг огцом буурсантай холбоотой харилцаа холбооны салбар мөн бууралттай байсан бол алтны ханш өсөж байгаатай холбоотой түүхий эд олборлогч компаниудын ханш өсөлттэй байлаа.

Даваа гарагт Ерөнхийлөгчийн өдөр байсантай холбоотой АНУ-ын зах зээл хаалттай байлаа.

Даваа гарагт Ерөнхийлөгчийн өдөр байсантай холбоотой АНУ-ын зах зээл хаалттай байлаа.

**Европ:** COVID-19-ийн тархалт бүс нутгийн эдийн засагт үзүүлэх нөлөө бага байгаатай холбоотой бизнесийн үйл ажиллагаа хүлээлтээс илүү түвшинд идэвхжиж байгаагаас үүдэн Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд долоо хоногийн эхэн үеийн алдагдлуудаа нөхөн өөрчлөлт багатай хаагдлаа.

IHS Markit агентлагаас Еволбүсийн ерөнхий худалдан авагч менежерүүдийн индекс (PMI) үйлчилгээний салбарын үзүүлэлтүүд сайн байгаатай холбоотой 1-р сарын үзүүлэлт болох 51.3-аас өсөж 2-р сард 51.6 болсон гэж мэдээллээ. Энэхүү үзүүлэлт нь 50-аас дээш байх нь эдийн засгийн өсөлтийг илтгэдэг ба COVID-19-ийн тархалттай холбоотой нийлүүлэлтийн шугамуудад саатал үүссэн ч эрэлт их хэвээр байгаатай холбоотой энэхүү индекс өндөр байна. Үйлдвэрлэлийн PMI 50-с бага байгаа ч өнгөрөгч сарын 47.9-өөс ихсэн 49.1 хүрсэн нь шинжээчдийн таамаглаж байсан түвшинээс их байгаа юм. Энэхүү үзүүлэлтүүд нь ДНБ-ны 0.2%-ийн өсөлттэй нийцэж байна.

**Япон:** Энэ долоо хоногт Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд уналттай байсан ба Япон улсын иен нь зах зээлийн гэнэтийн шок болон геополитикийн эрсдэлийн эсрэг аюулгүй хөрөнгө оруулалт гэж үзэгддэг ч энэ долоо хоногт ам.долларын эсрэг иений ханш буурсан байна.

Даваа гарагт, Япон улсын эрх баригчид 2019 оны 4-р улиралд ДНБ өнгөрөгч оны мөн үетэй харьцуулахад 6.3%-аар буурсан гэж мэдээллээ. Энэхүү бууралт нь ихэнх шинжээчдийн таамаглаж байсан 3.7%-ийн бууралтаас маш бага байгаа ба өнгөрсөн 5 жилийн хамгийн муу үзүүлэлт болсон байна.

**БНХАУ:** БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд бодлогын хүү бууруулсан, төв банкнаас нэмэлт арга хэмжээ авах амлалт өгсөн, коронавирусын шинэ тохиолдлууд буурсан болон БНХАУ-ын зарим нэг мужуудад үйлдвэрүүд хүлээгдэж байснаас эрт нээгдэх магадлалтай гэсэн тайлан гарсантай холбоотой 2-р сарын 20-ны өдөр түүхэн ханшиндаа хүрч хаагдлаа. Үйлдвэрүүд дахин үйл ажиллагаагаа эхлүүлэх нь БНХАУ-ын богино хугацааны үйлдвэрлэлийн гарцад томоохон нөлөө үзүүлэхээр байгаа юм.

Эх сурвалж: Troweprice.com

| Олон улсын индексүүд | Улс        | Хаалт     | Өөрчлөлт |
|----------------------|------------|-----------|----------|
| MSE TOP 20           | Монгол     | 19,163.12 | 0.95% ▲  |
| Dow Jones            | АНУ        | 28,992.41 | -1.38% ▼ |
| S&P 500              | АНУ        | 3,337.75  | -1.25% ▼ |
| Nasdaq               | АНУ        | 9,576.59  | -1.59% ▼ |
| S&P/TSX              | Канад      | 17,843.53 | -0.03% ▼ |
| FTSE 100             | Их Британи | 7,403.92  | -0.07% ▼ |
| S&P/ASX 200          | Австрали   | 7,139.00  | 0.12% ▲  |
| Nikkei 225           | Япон       | 23,386.74 | -1.27% ▼ |
| Hang Seng            | Хонг Конг  | 27,308.81 | -1.82% ▼ |

| Бонд                   | Валют | Купон   | Үнэ    |
|------------------------|-------|---------|--------|
| Mongol 2024 (Хуралдай) | USD   | 8.750%  | 113.64 |
| Mongol 2023 (Гэрэгэ)   | USD   | 5.625%  | 102.61 |
| Mongol 2022 (Чингис)   | USD   | 5.125%  | 101.49 |
| Mongol 2021 (Мазаалай) | USD   | 10.875% | 107.29 |
| DBM' 23 (Самурай)      | JPY   | 1.520%  | 103.55 |
| DBM' 2023              | USD   | 7.250%  | 107.35 |
| TDBM' 2020             | USD   | 9.375%  | 101.03 |
| MGMTGE' 2022 (Өүлэн)   | USD   | 9.750%  | 97.65  |

| Зах зээлийн хүү | Хаалт | Өөрчлөлт |
|-----------------|-------|----------|
| Libor 1M        | 1.613 | -0.05 ▼  |
| Libor 3M        | 1.638 | -0.05 ▼  |
| Libor 6M        | 1.629 | -0.08 ▼  |
| Libor 1YR       | 1.646 | -0.15 ▼  |
| US 2YR Bond     | 1.141 | -0.29 ▼  |
| US 3YR Bond     | 1.123 | -0.27 ▼  |
| US 5YR Bond     | 1.130 | -0.29 ▼  |
| US 10YR Bond    | 1.322 | -0.26 ▼  |

| Валютын ханш | 2020.02.21 | Өөрчлөлт |
|--------------|------------|----------|
| USD          | 2,760.89   | 0.17% ▲  |
| CNY          | 392.55     | -0.54% ▼ |
| EUR          | 2,986.32   | -0.06% ▼ |
| RUB          | 42.90      | -1.24% ▼ |
| KRW          | 2.28       | -2.15% ▼ |
| JPY          | 24.71      | -1.59% ▼ |
| CAD          | 2,083.06   | 0.13% ▲  |

| Түүхий эд        | Хэмжих нэгж | Хаалт    | Өөрчлөлт |
|------------------|-------------|----------|----------|
| Алт /спот/       | USD/t oz.   | 1,643.41 | 3.75% ▲  |
| Мөнгө /спот/     | USD/t oz.   | 18.49    | 4.21% ▲  |
| Зэс              | USD/lb.     | 261.60   | 0.35% ▲  |
| Нүүрс            | USD/MT      | 67.60    | -4.69% ▼ |
| WTI газрын тос   | USD/bbl.    | 53.38    | 2.56% ▲  |
| Brent газрын тос | USD/bbl.    | 58.50    | 2.06% ▲  |

| Макро эдийн засгийн үзүүлэлтүүд  | Хугацаа | Хэмжээ  |
|----------------------------------|---------|---------|
| Инфляцийн түвшин                 | 2020. I | 5.6%    |
| Бодлогын хүү                     | 2020. I | 11.00%  |
| Банк хоорондын зах зээлийн хүү   | 2020. I | 10.86 % |
| Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/ | 2020. I | 11.42%  |
| Хадгаламжийн дундаж хүү /валют/  | 2020. I | 4.74%   |
| Зээлийн дундаж хүү /төгрөг/      | 2020. I | 17.06%  |
| Зээлийн дундаж хүү /валют/       | 2020. I | 10.30%  |

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 51 компанийн 420.0 сая төгрөгийн 3,584,421 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Тандэм инвест ББСБ” /VIK/ компанийн хувьцаа 31.25%-аар буюу хамгийн ихээр өсөж 26.25 төгрөг хүрч хаагдсан бол “Увс чацаргана” /CHR/ компанийн хувьцаа 27.27%-аар буурч 240.00 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

02-р сарын 21-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,765.7 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 19,163.12 нэгж болж, өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.95%-аар өссөн байна.



| Зах зээлийн тойм                            |  | Дүн (сая.төг) |               |
|---------------------------------------------|--|---------------|---------------|
| Арилжигдсан үнийн дүн                       |  | 420.0         |               |
| Зах зээлийн үнэлгээ                         |  | 2,765,657.2   |               |
| Зах зээлийн индексүүд                       |  | Хаалт         | Өөрчлөлт      |
| MSE Top 20                                  |  | 19,163.12     | 0.95% ▲       |
| MSE I индекс                                |  | 9,466.37      | 1.37% ▲       |
| MSE II индекс                               |  | 7,783.79      | 1.05% ▲       |
| Идэвхтэй арилжагдсан хувьцаа                |  | Ширхэг        | Үнийн дүн     |
| Мандал даатгал                              |  | 2,741,457     | 143,007,602   |
| АПУ                                         |  | 206,422       | 134,391,000   |
| Говь                                        |  | 87,268        | 22,040,679    |
| Улсын их дэлгүүр                            |  | 13,203        | 18,190,460    |
| Таван толгой                                |  | 2,096         | 13,637,510    |
| Өсөлттэй хувьцаа                            |  | Хаалт         | Өөрчлөлт      |
| Тандем инвест ББСБ                          |  | 26.25         | 31.25% ▲      |
| Женко тур бюро                              |  | 90.69         | 29.54% ▲      |
| Дархан нэхий                                |  | 15,800.00     | 12.86% ▲      |
| Ремикон                                     |  | 29.95         | 10.80% ▲      |
| Мандал даатгал                              |  | 52.59         | 7.33% ▲       |
| Бууралттай хувьцаа                          |  | Хаалт         | Өөрчлөлт      |
| Увс чацаргана                               |  | 240.00        | -27.27% ▼     |
| Монгол шилтгээн                             |  | 255.00        | -15.00% ▼     |
| Мерекс                                      |  | 17.00         | -14.96% ▼     |
| Силикат                                     |  | 41.00         | -14.58% ▼     |
| Материалимпекс                              |  | 8,000.00      | -12.47% ▼     |
| Арилжаанд идэвхтэй оролцсон ҮЦК             |  | Дүн (төг)     |               |
| Голомт Капитал                              |  | 275,261,216   |               |
| Би Ди Сек                                   |  | 110,462,335   |               |
| Стандарт Инвестмент                         |  | 90,520,274    |               |
| Ард Секюритиз                               |  | 68,472,811    |               |
| Ти Ди Би Капитал                            |  | 62,121,615    |               |
| Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани |  | Хаалт (төг)   | ЗЗҮ (сая.төг) |
| АПУ                                         |  | 653.98        | 695,953       |
| Таван толгой                                |  | 6,550.00      | 344,957       |
| МИК Холдинг                                 |  | 14,800.00     | 306,498       |
| Говь                                        |  | 256.66        | 200,224       |
| Инвескор ББСБ                               |  | 2,652.00      | 190,222       |

Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа

| № | Үнэт цаасны нэр | Арилжигдсан ширхэг | Үнийн дүн /төг/ | Доод /төг/ | Дээд /төг/ | 7 хоног | Хүү |
|---|-----------------|--------------------|-----------------|------------|------------|---------|-----|
| - | -               | -                  | -               | -          | -          | -       | -   |

## НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

| №  | СИМБОЛ | КОМПАНИЙН НЭР                | 2019 ОНЫ<br>ЦЭВЭР АШИГ<br>/САЯ ТӨГ/ | НИЙТ ХУВААРИЛАХ<br>НОГДОЛ АШИГ<br>/САЯ ТӨГ/ | НОГДОЛ<br>АШИГ<br>ТӨЛӨЛТИЙН<br>ХАРЬЦАА | НЭГЖ<br>ХУВЬЦААНЫ<br>НОГДОЛ<br>АШИГ<br>/ТӨГ/ | БҮРТГЭЛИЙН<br>ӨДӨР | ХУВААРИЛАХ<br>ӨДӨР         |
|----|--------|------------------------------|-------------------------------------|---------------------------------------------|----------------------------------------|----------------------------------------------|--------------------|----------------------------|
| 1  | APU    | АПУ                          | 74,411.5                            | 75,471.2                                    | 101.4%                                 | 71.0                                         | ХУРЛЫН<br>ӨДРӨӨР   | 2020.08.31-НИЙ<br>ДОТОР    |
| 2  | MNDL   | МАНДАЛ ДААТГАЛ               | 5,820.3                             | 2,497.2                                     | 42.9%                                  | 4.0                                          | ХУРЛЫН<br>ӨДРӨӨР   | 2020.06.30-НЫ ДОТОР        |
| 3  | GTL    | ГУТАЛ                        | 2,403.7                             | 2,436.0                                     | 101.3%                                 | 1,520.0                                      | 2020.03.13         | 2020.05.05-НЫ ӨДӨР         |
| 4  | LEND   | ЛЭНДМН                       | 4,910.2                             | 1,200.0                                     | 24.4%                                  | 1.5                                          | 2020.02.25         | 2020.04.30-НЫ<br>ӨДӨР      |
| 5  | ADB    | АРД КРЕДИТ ББСБ              | 2,369.4                             | 1,184.7                                     | 50.0%                                  | 4.2                                          | 2020.04.08         | 2020.06.30-НЫ<br>ДОТОР     |
| 6  | AARD   | АРД САНХҮҮГИЙН<br>НЭГДЭЛ     | 715.9                               | 1,000.0                                     | 139.7%                                 | 35.0                                         | 2020.04.07         | 2020.04.30-НЫ<br>ДОТОР     |
| 7  | TUM    | ТҮМЭН ШУВУУТ                 | 3,232.9                             | 960.0                                       | 29.7%                                  | 4.8                                          | ХУРЛЫН<br>ӨДРӨӨР   | 2020.06.24-НЫ<br>ӨДӨР      |
| 8  | AIC    | АРД ДААТГАЛ                  | 1,718.7                             | 850.0                                       | 49.5%                                  | 34.0                                         | 2020.04.09         | 2020.06.30-НЫ<br>ДОТОР     |
| 9  | JTB    | ЖЕНКО ТУР БЮРО               | 1,253.8                             | 799.9                                       | 63.8%                                  | 10.0                                         | ХУРЛЫН<br>ӨДРӨӨР   |                            |
| 10 | TEX    | ТЕХНИК ИМПОРТ                | 2,718.2                             | 723.4                                       | 26.6%                                  | 500.0                                        | 2020.03.1          | 2020.04.24-НИЙ<br>ӨДРӨӨС   |
| 11 | BUK    | УЛААНБААТАР БУК              | 2,465.3                             | 526.2                                       | 21.3%                                  | 4.0                                          | ХУРЛЫН<br>ӨДРӨӨР   | 2020.06.01-НИЙ<br>ӨДРӨӨС   |
| 12 | MMX    | МАХИМПЕКС                    | 819.3                               | 456.1                                       | 55.7%                                  | 120.0                                        | ХУРЛЫН<br>ӨДРӨӨР   | 2020.10.01-НИЙ<br>ӨДРӨӨС   |
| 13 | MFC    | МОНОС ХҮНС                   | 761.9                               | 408.9                                       | 53.7%                                  | 1.0                                          | ХУРЛЫН<br>ӨДРӨӨР   | 2020.08.31-НИЙ<br>ДОТОР    |
| 14 | DSS    | ДАРХАН СЭЛЭНГИЙН<br>ЦТС      | 581.8                               | 391.8                                       | 67.3%                                  | 37.7                                         | 2020.03.20         |                            |
| 15 | MNP    | МОНГОЛ ШУУДАН                | 1,103.6                             | 331.1                                       | 30.0%                                  | 3.3                                          | ХУРЛЫН<br>ӨДРӨӨР   | 2020.05.01-НИЙ<br>ӨДРӨӨС   |
| 16 | HRM    | ГЕРМЕС ЦЕНТР                 | 820.0                               | 322.0                                       | 39.3%                                  | 4.1                                          | 2020.02.28         | 2020.03.15-НЫ<br>ӨДРӨӨС    |
| 17 | NEH    | ДАРХАН НЭХИЙ                 | 2,327.6                             | 230.8                                       | 9.9%                                   | 210.0                                        | 2020.02.25         | 2020.09.30-<br>2020.12.30  |
| 18 | TCK    | ТАЛХ ЧИХЭР                   | 2,456.0                             | 230.3                                       | 9.4%                                   | 225.0                                        | ХУРЛЫН<br>ӨДРӨӨР   | 2020.06.20-НООС.           |
| 19 | MBW    | МОНГОЛ БАЗАЛЫТ               | 335.0                               | 225.7                                       | 67.4%                                  | 4.0                                          | 2020.03.09         | 2020-06-30-НЫ ДОТОР        |
| 20 | BNG    | БАЯНГОЛ ЗОЧИД<br>БУУДАЛ      | 2,117.8                             | 152.3                                       | 7.2%                                   | 360.0                                        | ХУРЛЫН<br>ӨДРӨӨР   | 2020.09.01-НИЙ<br>ӨДРӨӨР   |
| 21 | BDS    | БИДИСЕК                      | 19.9                                | 136.9                                       | 687.0%                                 | 10.0                                         | 2020.03.09         | 2020.12.31-НЫ<br>ДОТОР     |
| 22 | EER    | АРИГ ГАЛ                     | 225.8                               | 131.0                                       | 58.0%                                  | 38.9                                         | ХУРЛЫН<br>ӨДРӨӨР   | 2020.06.30-НЫ<br>ДОТОР     |
| 23 | TAN    | ТАХЬКО                       | 489.0                               | 128.5                                       | 26.3%                                  | 108.0                                        | ХУРЛЫН<br>ӨДРӨӨР   | 2020.05.01-НИЙ<br>ДОТОР    |
| 24 | UBH    | УЛААНБААТАР ХИВС             | 298.8                               | 121.4                                       | 40.6%                                  | 300.0                                        | 2020.03.06         | 2020.05.01-15НЫ<br>ХООРОНД |
| 25 | HRD    | ХҮРД                         | 722.6                               | 72.4                                        | 10.0%                                  | 535.0                                        | 2020.03.02         | 2020-06-30-НЫ ДОТОР        |
| 26 | ATR    | АТАР ӨРГӨӨ                   | 280.4                               | 60.9                                        | 21.7%                                  | 350.0                                        | ХУРЛЫН<br>ӨДРӨӨР   | 2020.08.01-НЫ<br>ДОТОР     |
| 27 | MCH    | МОНГОЛЫН<br>ЦАХИЛГААН ХОЛБОО | 62.0                                | 25.9                                        | 41.7%                                  | 1.0                                          | ХУРЛЫН<br>ӨДРӨӨР   | 2020.06.01-НИЙ<br>ӨДРӨӨС   |
| 28 | HUV    | ХӨВСГӨЛ ГЕОЛОГИ              | 324.7                               | 21.6                                        | 6.7%                                   | 150.0                                        | 2020.04.03         | 2020.05.01-ООС<br>ХОЙШ     |

## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

### ОНЦЛОХ МЭДЭЭ



Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан АНУ-ын ЭСЯ-ны Нэгдүгээр нарийн бичгийн дарга Бенжамин Рой, АНУ-ын сангийн яамны Техникийн туслалцааны албаны суурин төлөөлөгч Н.Клайд Родс нарыг хүлээн авч уулзав.

Энэ үеэр Хорооны зүгээс Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог сайжруулахын тулд хийж буй ажлыг танилцуулж, СЗХ-ны зохицуулалтад шинээр нэмэгдэж орсон үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага, үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн эрсдэлийг үнэлэх, зохицуулалтыг сайжруулах чиглэлээр санал солилцож, хамтын ажиллагааны боломжуудын талаар ярилцлаа.

### ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН МЭДЭЭЛЭЛ

Компанийн тухай хуулийн 46-р зүйл, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 56-р зүйлийн 56.2.1, СЗХ-ны “Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын тухай журам”-ын 1-р зүйлийн 1.3 дахь заалт, 2-р зүйлийн 2.3.5 дахь заалтад тус тус заасны дагуу Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй компани нь ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэрээ жил бүрийн 2-р сарын 20-ны өдрийн дотор ирүүлж, нийтэд мэдээлэх үүрэгтэй байдаг билээ.

2020 оны 2-р сарын 20-ны өдрийн байдлаар бүртгэлтэй нийт 198 компаниас нэр бүхий 94 компани хууль журмын дагуу шийдвэрээ ирүүлээд байна. Эдгээр компаниудаас 28 компани нь ногдол ашиг хуваарилах, 2 компани хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх, харин үлдсэн 64 компани нь ногдол ашиг хуваарилахгүй тухай шийдвэр ирүүлсэн байна.



### БУСАД МЭДЭЭ

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02-р сарын 17-ны өдрийн 09-р тогтоолоор нэгж хувьцаанд 90 төгрөгийн ногдол ашгийг иргэд, аж ахуйн нэгжийн эзэмшиж буй хувьцаанд мөнгөн хөрөнгөөр хуваарилахаар шийдвэрлэсэн бөгөөд ногдол ашгийг 2020 оны 5-р сарын 01-ний өдрөөс эхлэн олгох ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахаар болсон.

Энэхүү шийдвэр гарсантай холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хорооноос дараах мэдэгдлийг хийж байна:

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 01-р сарын 29-ний өдрийн 28-р тогтоолоор хувьцаат компаниудын ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох асуудлыг хэлэлцэж, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор хувьцаат компаниудын ногдол ашгийг зөвхөн “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-аар зуучлуулан тарааж байхыг хувьцаат компаниудын удирдлагуудад даалгасан тул хувьцаа эзэмшигчид өөрийн харилцагч брокероороо дамжуулан ногдол ашгаа авна.

Хувьцаа эзэмшигч үнэт цаасны дансаа нээлгээгүй байсан ч ногдол ашгийн мөнгөн хөрөнгө “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК дээр хадгалагдах бөгөөд ногдол ашгийг хуваарилах ажиллагаа нь 2020 оны 5-р сарын 01-ний өдрөөс эхлэх тул шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх үүднээс мөн Монгол Улсын Засгийн газраас хуулийн этгээдүүдийг “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”-т хэсэгчлэн шилжүүлсэн байгаа энэ үед өөртөө болон бусдад эрсдэл үүсгэхгүй, хэт яаравчлахгүй байдлаар үнэт цаасны дансаа нээлгэх ажлаа зохион байгуулах нь зүйтэй.

## ЗАХ ЗЭЭЛИЙН БУСАД МЭДЭЭ

### ОНЦЛОХ МЭДЭЭ

- Fitch: Хойд азийн орнуудаас монгол улсад covid-19-ээс үүдэлтэй эрсдэл өндөр байна.
- Улсын онцгой комисс хүнсний хомсдол үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахыг чиглэл болгов.
- Засгийн газар болон “Оюу Толгой” төслийн хөрөнгө оруулагч талтварын маргаанаа арбитраар шийдүүлэхээр болов



### МАКРО ЭДИЙН ЗАСАГ

Төсвийн орлого өмнөх онтой харьцуулахад одоогоор 202.7 тэрбум төгрөгөөр дутуу байна. Шинэ төрлийн “коронавирус”-ээс үүдсэн нөхцөл байдал цаашид үргэлжилбэл төсвийн орлого нэг их наяд төгрөгөөр дутуу орж ирэх төлөвтэй байгааг Сангийн сайд мэдээллээ.

Мөн нүүрс, газрын тосны экспортын асуудлаар БНХАУ-ын талтай сайн ойлголцох ёстой гэсэн байр суурьтай байна. “Төсвийн дутагдлын тухайд одоогоор тодотгол хийхгүй. Нөхцөл байдалд уялдуулан зарцуулалт хийх боломжтой”-г онцолсон юм. 2020 онд Монгол Улс төсвийн орлого зарлагаа өмнө нь байгаагүй хэмжээнд хүргэж тэлсэн бөгөөд төсвийн алдагдлыг хоёр их наяд төгрөг байхаар батлаад байгаа юм.

### ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

“Kincora Copper” компани Австралийн Нью Саут Уэльс муж дахь “Rarex Resources” компанийн төслүүд дэх 65 хувийн эзэмшлийг нь худалдаж авахаар болсон байна.

Энэхүү хэлцэлтэй холбоотой холбогдох баримт бичгийг Торонтогийн Хөрөнгийн биржид хүргүүлжээ. Энэхүү хэлцлээр дамжуулан “Kincora Copper” компани Австралийн порфир зэсийн голлох бүс нутагт үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр зорьж байна. “Kincora Copper” компани Монголд “Хүрэл үнэг”, “Зүүн Цагаан Суварга” төслийн талбайд идэвхтэй хайгуул хийж байгаа аж. Мөн сүүлд “Ivohoe Mines Mongolia” компанийн хайгуул хийж байсан алт, зэсийн “Бадрах” төсөлд хайгуул хийхээр болсноо мөн зарласан байна.



### МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.